## Бахайн шүтлэгийн ордон

**Чухал тэмдэглэлт өдрүүд**

Суурын чулууг тавьсан 1912

Барилгын ажлыг эхэлсэн 1921

Барилгыг дуусгаж үүдээ нээсэн 1953

**Багтаамж**

Танхим нь 1,192 хүний суудалтай

**Хэмжээ**

Танхимийн дотоод өндөр нь 42 метр

Бүмбэгэр оройн тойргийн диаметер 27.5 метр

**Хүрэлцэн ирэх цагууд**

10 сарын 1- 4 сарын 30

Танхимд Өглөөний 6ц - оройн 10 ц

Хүрэлцэн ирэгчдэд үйлчлэх төв :

Өглөөний10ц-орой 5 ц

5сарын 1 - 9 сарын 30

Танхим Өглөөний 6ц - оройн 10 ц

Хүрэлцэн ирэгчдэд үйлчлэх төв :

Өглөөний10ц-орой 8 ц

**Бишрэлийн цуглаан:** Богино хэмжээний

бишрэлийн цуглаан өдөр тутам өглөөний 9:15,

өдрийн 12:30 ба оройн 5:15мин тутамд өдөр бүр.

**Тойрон аялалын мэдээлэл**

Багаар аялах хүмүүс 847-853-2300 номерт залгана уу.

Цөөхөн хүнтэй баг болон хувь хүмүүс урьдчилан мэдээлэх шаардлагагүй чөлөөтэй хүрэлцэн ирж болно.

**Хаяг:** 100 Линдэн өргөн чөлөө , Вилмет, Иллинойс 6009



**Цахилгаан шуудан:** how@usbnc.org

**Утас:** 847-853-2300

**Вэб хаяг:** www.bahaitemple.org, www.bahai.us, or www.bahai.org

### Орц болон үүдний танхим дах Сургаалт бичмэлүүд

Шүтлэгийн ордонд зочлогчид орц болон үүдний танхимуудыг холбосон Баха-У-ллагийн 18 сургаалт бичмэлүүдийг харах болно.

**Орцын дээд талд:**

Эх дэлхий бол нэгэн улс гүрэн хүн төрөлхтөн бол иргэд нь юм.

Бүх зүйлийн дотроос миний хараанд хамгийн их хайрлагдсан зүйл бол шударга ёс, хэрэв чи намайг хүсвэл түүнээс бүү нүүр буруул.

Миний хайр бол Миний өмөг түшиг түүнд нэвтрэн орсон хэн боловч амар мэнд аюулгүй байх болно.

Бусдын нүглээр бүү тохуурх Чи өөрөө нэгэн адил нүгэлтэн.

Чиний зүрх бол миний орших орон. Намайг түүнд бууж орохоор түүнийг ариун байлга.

Би чамд зориулж баяр жаргалын элчийн үхлийг бүтээсэн байхад юунаас болж чи уй гашуунд автана вэ?

Миний газар дэлхий дээр намайг дурсаж бай Тэгвээс би чамайг өөрийн диваажинд дурсах болно.

Өө, Газар дэлхийн дээрх баян нэгэн! Та бүхний дунд орших ядуус бол Миний итгэл, Миний итгэлийг харж хамгаалж бай.

Бүх суралцаж буй зүйлсийн уг сурвалж бол Бурханы эрдэм , Түүний сүр жавхлан өргөмжлөгдөг.

**Үүдний хонгилууд дотор:**

Бурханы бүх зөнч мэргэд нар, бүгд нэгэн сүсэг бишрэлийг тунхагласан юм.
Шүтлэг бол гялалзсан гэрэл ба дийлдэшгүй бат цайз юм.
Та нар бол нэгэн модны үр жимс ба нэгэн мөчирийн навчис
Эв нэгдлийн гэрэл гэгээ үнэхээр хүчирхэг ба энэ нь бүхий л ертөнцийг гэрэлтүүлж чадна.
Бүх шашнуудын дагалдан шүтэгч нараа Нөхөрсгөөр хамтран нэгдэцгээ.
Өө, Ахуйн үрээ,
Миний хайрын төлөө миний шийдвэр дотор алх.
Таны диваажин бол Миний хайр
Таны тэнгэрлэг орон бол надтай нэгдсэн нэгдэл юм.
Сайн зан чанарын гэрэл гэгээ нарны гэрэлээс илүү давуу.



# Тавтай Морил

### Хойд Америк Тив Дэх Бахай Бишрэлийн Ордон

### Иллинойс Муж, Вилмет хот

Өнөөгийн түвшинд дэлхийн хэмжээнд Бахайн бишрэлийн долоон ордон байдаг бөгөөд тэдгээрийн ер бусын тогтолцоо нь эв нэгдэл болон Бурханд мөргөх мөргөлд урин дуудаж байдагт оршино. Бишрэлийн ордон тус бүр өвөрмөц загвараар бүтээгдсэн байдгаас гадна, бүгд тогтмол нэг санаа болох: цэцгийн хүрээлэнгээр хүрээлэгдсэн 9 өнцөг бүхий ордон нь сүр жавхлант пүмбэгэр оройгоор бүрхэгдсэн байдагт оршино. ( Энэ нь бүх хүмүүс ба шашин шүтлэг нь бурханы нэрийн дор эвсэн нэгдэхийн билэг тэмдэг)

Вилметт дахь Шүтлэгийн ордон нь 30 гаруй жилийн барилга байгууламжын ажлын дараа 1953 онд анх үүдээ нээсэн.

Франц-Канадын иргэн уран барилгын мэргэжилтэн Луис Боуржуа үнэхээрийн ариун дээд санаа зорилгод таарахуйц тийм загварийг бүтээхийн тулд 8 жилийн турш хөдөлмөрлөсөн юм. Боуржуагийн зургийг бат бөх хээ хуаран чимэглэл болгон шилжүүлэн буулгахад зарим шаардлагууд нь-100 фут (32м 70 см) урт цаас-болон ордоны хэцүү түвэгтэй гадна талын торон чимэглэлийг бөх бат болгон хэлбэржүүлэн гаргахад бетонон хавтанг өөрчлөн зохиож , өөхөн цагаан чулууны талст ба цагаан цементээр шинэчлэн цутгаж хийхэд хүргэсэн юм. Яг адил болон бие биедээ таарах хэмжээний зуу зуун ижил бетонон хэрчим хэсгүүдийг ордоны ган давхарлага дээр өлгөж хийсэн.

**Цорын Ганц , Ариун Оршихуй**

Бүх хүмүүсийг уэсгэлэнт ба гэгээт оршихуйд Бурханд мөргөн , бясалгах үйлд урин дуудаж байдаг энэхүү цэцэрлэгт хүрээлэн бүхий байгууламж нь цорийн ганц бөгөөд ариун орон юм. Бахайн шүтлэг нь гоо сайхны үнэ цэнийг өйлгон үнэлдэг. Бурханы үг нь эрин зуун тутамд - соёл иргэншлийн шинэчлэлийн харааг бүтээн- бодит үнэн байдал болон гоо сайхны аль алиныг нь илрүүлэн илчилж байдаг.

**Бахайн шүтлэг- Эв нэгдлийн шашин**

Бахайн шүтлэг нь дэлхийн бараг бүх ястан угсаатнуудын 5 тэрбум гаруй хүмүүсийн хэрэглэж буй биеэ даасан үндсэн шүтлэг юм. Бид нар нэгэн хүн төрөлхтөн үндэстэн, бүх шашин нэгэн эх үүсвэртэй , нэг зорилгын төлөө хамтран зүтгэдэг , дэлхийн ариун судруудад амлагдаж , удаан хугацаагаар хүсэн хүлээгдсэн найрамдлын зуун одоо биелэлээ олж байна гэсэн итгэлээр тэд тус шүтлэгт татагддаг.

**Бахайн шүтлэгийн үндсэн зарчмууд**

Сэжиглэн ялгаварах мухар сүсэгийг арилгах

Эрэгтэй эмэгтэй хүмүүсийн тэгш эрхийг хангах

Шашин ба шижлэх ухааны нийцэл

Дэлхийн засаглалын дагуу энх тайвныг баримтлах

Эдийн засгийн асуудлуудын оюун санааны шийдвэр

Бүх нийтийн боловсрол

**Бахайн шүтлэгийг онцгой болгох зүйл: Дэвшилтэт нээлт**

Түүхийн туршид Бурхан хүн төрөлхтөнд өөрийгөө нээсээр ирсэн ба түүхэнд тэмдэглэгдсэн өдрүүдээс өмнөх, алс эртний үеэс эхлэн цуван ирсэн бурханы элчүүд Абрахам, Мосес, Кришна, Будда, Зороастер, Крист ба Мухамед -аар дамжуулан бурхан өөрийнхөө сургаалыг хүн төрөлхтөнд заасаар ирсэн гэж Бахайчууд итгэдэг. Бурханы эдгээр тайлалуудын гол үүрэг нь соёл иргэншилийн оюун санааны хувьсалуудын удаа дараалсан үе шатуудыг илэрхийлэх явдал юм. Бахайчууд , Баха-у-ллаг эдгээр тэнгэрлэг элч нараас хамгийн сүүлд ирсэн, энэ эрин үед амлагдсан нэгэн гэж гэж танин ойлгодог.

**Бахай шүтлэгийн түүх**

Бахайн шүтлэгийг Перс улсад (одоогийн Иран) Мирза-Хусайн-Али (1817-1892) буюу Баха-У-лла гэж алдаршсан (орчуулбаас " Бурханы Яруу алдар" ) үндэслэсэн юм. Бурханы хамгийн сүүлийн элчийн хувьд, түүний үүрэг зорилго бол Вав (Үүд) гэж нэршсэн Сийд Али Мухаммедын (1819-1850) зөгнөн хэлж байсан дэлхийн энх тайвны эрин рүү орох үүдийг нээж өгөх явдал байсан юм. Шүтлэгийг заасны улмаас Баха-у-лла бараг бүх амьдралаа Перс, Туркийн засгийн газрын цөллөгө ба шоронд хоригдож өнгөрүүлсэн юм. 1868 онд Тэрээр Палестин (одоогийн Израел) дахь Акрегийн шоронгийн хотод цөлөгдөж 1892 онд тэндээ нас барсан юм. Баха-у-лла ,Түүний шүтлэгийн Дэлхийн төв нь Найфа-Аккад байх болно гэж онцлон заажээ.

**Шүтлэгийн ордон нь гэрэл гэгээ ба эв нэгдэлийн төлөө сүндэрлэн зогсоно**

Сүмийн уран барилгын зохион бүтээгч Луис Боуржуа сүмийн чимэглэлийн хээ хуарыг, Баха-у-ллагаар дамжуулан нээн илрүүлсэн Бурханы шинэ үүдэл нээлтийн гэрэл - хуран цуглардын гэрлийн биежилт болгон дүрслэн хийжээ. Баруун ба зүүний аль ч өвөрмөц соёлыг хэтрүүлэн дууриагаагүй харин дэлхийн бүх оршин суугчид хүрч ирээд мөргөлөөр нэгдэх тийм хосгүй хэлбэрийг гарган Сүмийн загварыг бүтээсэн юм.



Сүмийн бүмбэгэр оройд тохируулан байрлуулсан Араб **Бэлэг тэмдэг** үг, "Яа Баха-у-лла" нь-- Бурханы Яруу- алдар гэсэн мөргөлийн үг .



"Цамхагийн хээ чимэглэл дотор аливаа шашныг төлөөлөн харуулсан хуучин үеийн шашны бэлэг тэмдгүүдийг сүлжээлэн оруулалаа: Дэлхийн ахан дүүсийн эв нэгдлийн үлгэр жишээ болсон Бунханд тавтай морил."

--Луис Боржуа

**Хүчирхэг Нэгдмэл амьдрал**

Хүчирхэг, дэмжигч, хайрын эв нэгдлийг бий болгохийн тулд бахайчууд хамтран цуглардаг. Хэн оролцох хүсэлтэй хүмүүст цуглаан , төсөл болон тэдгээрийн үйл ажиллагаанд орох боломжийг олгодог. Тэдгээр үйл ажиллагааны дотор:

**Харилцан суралцах бүлгүүд** нь Амьдралын зорилго, Сүнсний мөн чанар гэх мэт янз бүрийн сэдвүүд дээр ярилцан судалдаг.

**Мөргөлийн цуглаанууд** дээр янз бүрийн гарал үүсэл, шашин шүтлэгтэй хүмүүс цугларч , тааламжтай уур амьсгалтай орчинд мөргөл үйлддэг

**Хүүхдийн хичээлүүд** нь итгэл даах чадвар, шударга ёс, сайхан сэтгэл гэх мэт ёс суртахууны болон оюун санааны сайн зан үйлүүдийг янз бүрийн үйл ажиллагаагаар дамжуулан суралцдаг.

**Өсвөр насны залуусыг хүчирхэгжүүлэх хөтөлбөрөөр** үйлчилгээ, нөхөрлөл болон урлан бүтээх зэрэг сургалтуудыг явуулан залуу өсвөр үеийнхнийг хөгжиж дэвшихэд нь тусалдаг.

**Бахайн Шүтлэг Америкийн Нэгдсэн Улсад**

1893 онд, АНУ-ын Чикаго хотноо Дэлхийн шашны Парламентад Бахайн Шүтлэгийг танилцуулснаас хойш хойд Америкад тус шүтлэг улам бүр өсөн нэмэгдсээр байна. Өнөөгийн байдлаар Америкад Индианчуудын зуу гаруй тусгаарлагдмал нутаг, дотоодын янз бүрийн мужуудыг оролцуулан 155.000 гаруй бахайчууд байна.Калифорни, Жиоржио, Иллиноис болон Тексас мужид хамгийн олон бахайчууд байдаг.

Ёсон гишүүнээс бүрдсэн Америкийн Нэгсэн Улсын Үндэсний оюун Санааны Чуулган нь Бахайчуудын нэгдлээс сонгогдсон тэдний удирдах байгууллага бөгөөд энэ нь Иллиноис мужийн Вилмэт хотод, Бахайн Шүтлэгийн ордоны ойролцоо байрладаг юм.

**Бахайн шүтлэгийн талаар цаашид суралцахад:**

Дэлхийн хэмжээнд бахайчууд сургалтын дугуйлан, бурханд сүсэглэх цуглаан болон хүүхдийн хичээлүүдийг эрхлэн явуулдаг бөгөөд үүнд бүх хүмүүс оролцох боломжтой.

Таны ойролцоо орших Бахайн байршлыг олохын тулд 1-800-22UNITE (1-800-228-6483) утас руу залгана уу. Эсвэл www.bahai.us.org. эсвэл www.bahai.org. руу орж үзнэ үү.

Бахайн бишрэлийн ордонд өдөр тутам болдог сүсэглэлийн хөтөлбөр, танилцуулах хичээлүүд , суралцах дугуйлан , мэдээлэх цуглаанууд мөн хүрэлцэн ирэгчдийн тойрон аялал зэрэгт бүх хүмүүс тавтай морилно уу. Магадгүй та янз бүрийн хэл дээрх шүтлэгийн тухай ном зохиолуудыг шилж авахын зэрэгцээ таны ойролцоо орших Бахайчуудтай яаж холбоо тогтоох гэх мэт цааших мэдээллүүдийг агуулсан сонирхлын үнэмлэхийг бөглөж болох юм.

**Бахай болох хүн** энэ эрин үед Бурханаас ирсэн элч Баха-У-ллаг танин ойлгож түүний сургаал болон хуулиудыг даган мөрдөх амлалтаа Бахайн Нэгдэлд мэдэгднэ.

**Зөвхөн Бахайчууд хандив өргөнө**
Бахайн шүтлэгтэй холбоотой бүх үйл ажиллагааны зардал нь Дэлхийн бахайчуудын өглөг хандиваас бүрддэг. Бахайн санд хандив өргөх нь зөвхөн бахайчуудад олгогдсон оюун санааны давуу эрх юм. Бахайн шүтлэгийн гишүүн бус хүмүүсээс хандивыг хүлээн авахгүй.